

1. Танилцсан: Тамгын газрын захирал

П.Эрдэнэтуяа

2. Танилцсан: Тамгын газрын ҮААХ-ийн захирал

Г.Нямсүрэн

3. Хянасан: Тамгын газрын төсвийн ахлах мэргэжилтэн

О.Бадамцоо

4. Боловсруулсан: Тамгын газрын ҮААХ-ийн худалдан

авалтын мэргэжилтэн

Э.Хурц

**МОНГОЛБАНКНЫ ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**
(2016 оны 3 дүгээр улирлын байдлаар)

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А-25 дугаар тушаалаар 2016 оны бараа, ажил, үйлчилгээ худалдах, худалдан авах төлөвлөгөөг тушаалаар баталсан.

Дээр дурдсан төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон “Монголбанкинд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай журам”-ыг мөрдөн ажиллаж байна.

Монголбанкны 2016 оны тендерийн ерөнхий мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг зэрэг мэдээллийн “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 7, 8 дугаар хавсралт дахь загварын дагуу боловсруулсан, Монголбанкны цахим хуудсанд байршуулан, тухай бүр шинэчилж байна. (мэдээллийг цахим хуудасны <http://www.mongolbank.mn/shilendans.aspx> холбоосноос үзнэ үү)

Нэг. Нээлттэй тендер шалгаруулалтаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тухай

Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг “Өнөөдөр”, “Өдрийн сонин” болон Монголбанкны цахим хуудсанд тухай бүр мэдээлсэн болно. Монголбанк 2016 онд дор дурдсан 5 нээлттэй тендер шалгаруулалт одоогийн байдлаар зарлаад байна

1. Монголбанкны ажлын хэрэгцээнд зориулан сервер, сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлэх. SR-2016/01

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-37 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Үнэлгээний хороо нээлттэй тендер шалгаруулалтыг нийт 7 байгууллагын дунд зарласан ба 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар судалж үзээд “Саммит компьютер технологи” ХХК-ийн ирүүлсэн

тендерийн материалыг “хамгийн сайн үнэлэгдсэн” тендерээр шалгаруулж 2016 оны 05 дугаар 03-ны өдөр гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг хүргүүлсэн. Монголбанк “Саммит компьютер технологи” ХХК-тай 2016 оны 06 дугаар сарын 13-ны өдөр сервер, сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээг байгуулсан. “Саммит компьютер технологи” ХХК гэрээнд заасан үүргийн дагуу ажил үүргээ 120,576,280.00 төгрөгөөр гүйцэтгэсэн гэж дүгнэлээ.

2. Монголбанкны “А” байрны хаалга шинэчлэх ажил гүйцэтгэх. DR-2016/01

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-36 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Үнэлгээний хорооны нээлттэй тендер шалгаруулалтад нийт 3 байгууллага материал ирүүлсэн ба үүнэс судалж үзээд 2016 оны 06 дугаар сарын 22-ны өдөр “Ти Энд Жи” ХХК-ны ирүүлсэн тендерийн материалыг “хамгийн сайнаар үнэлэгдсэн” тендерээр шалгаруулж 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдөр “Монголбанкны “А” байрны хаалга шинэчлэх ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулсан. “Монголбанкны “А” байрны хаалга шинэчлэх ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу “Ти Энд Жи” ХХК нь гэрээнд заасан хугацаанд бараагаа 93,979,306.00 төгрөгөөр нийлүүлэн заасан үүргийн дагуу ажил үүргээ гүйцэтгэсэн гэж дүгнэж байна.

3. Монголбанкинд автомашин нийлүүлэх. CR-2016/01

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-38 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Нээлттэй тендер шалгаруулалтыг 3 багцад зарласан бөгөөд тендерийн баримт материалыг нийт 6 байгууллага авсан. Эдгээрээс 2 байгууллага тендерийн материал ирүүлсэн байна. Эдгээр байгууллагуудын Багц 1-д ирүүлсэн тендерийн баримт материалыг 2016 оны 03 дугаар сарын 29-ний өдөр судалж үзээд “Таван богд” ХХК, мөн өдөр Багц 2-д ирүүлсэн тендерийн материалыг судалж үзээд “Моннис моторс” ХХК-ийн ирүүлсэн тендерийн материалууд тус тус “хамгийн сайн үнэлэгдсэн” тендерээр шалгаруулсан. Мөн багц 3-д ирүүлсэн материалыг судалж үзээд “Моннис моторс” ХХК-ийн ирүүлсэн материалыг “хамгийн сайн үнэлэгдсэн” тендерээр шалгаруулж 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдөр гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Тендер шалгаруулалтын дагуу дараах гэрээнүүдийг байгуулсан байна. Үүнд:

- “Таван богд” ХХК-тай 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр “Монголбанкинд автомашин нийлүүлэх гэрээ” 119,000,000.00 төгрөгөөр байгуулсан

- “Моннис моторс” ХХК-тай 2016 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр “Монголбанкинд автомашин нийлүүлэх гэрээ” 322,900,000.00 төгрөгөөр байгуулсан. Эдгээр компаниуд нь ажил үүргээ гэрээнд заасан үүргийн дагуу гүйцэтгэсэн гэж үнэлэгдсэн болно. Нийт 441.0 сая төгрөгөөр 4 ширхэг автомашин худалдан авсан.

1. Ниссан Патрол 2ш нийт 177.0сая

2. Ниссан Патрол 1ш 145.0сая

3. Тоёото Альфард 1ш 119.0сая

4. Монголбанкны ажлын хэрэгцээнд зориулан компьютер нийлүүлэх. PC-2016/01

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-39 тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Үнэлгээний хорооны нээлттэй тендер шалгаруулалтыг 2 багцад зарласан бөгөөд нийт 8 байгууллага авсан. Эдгээрээс 6 байгууллага тендерийн баримт материалыг ирүүлсэн байна. Эдгээр байгууллагуудын Ширээний компьютер нийлүүлэх буюу Багц 1-д ирүүлсэн тендерийн баримт материалыг 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр судалж үзээд “Саммит компьютер технологи” ХХК-ийн материал, мөн өдөр Зөөврийн компьютер нийлүүлэх буюу Багц 2-д ирүүлсэн материалыг судалж үзээд “Ай Ти Зон” ХХК –ийн ирүүлсэн материалуудыг тус тус “хамгийн сайн үнэлэгдсэн” тендерийн материалаар шалгаруулж 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг хүргүүлсэн.

Тендер шалгаруулалтын дагуу дараах гэрээнүүдийг байгуулсан байна. Үүнд:

- “Саммит компьютер технологи” ХХК-тай 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдөр 138,371,200.00 төгрөгөөр
- “Ай Ти Зон” ХХК-тай 2016 оны 05 сарын 17-ны өдөр “Монголбанкны ажлын хэрэгцээнд компьютер нийлүүлэх гэрээ” 65,685.620.00 төгрөгөөр тус тус байгуулсан

Эдгээр компаниуд нь ажил үүргээ гэрээнд заасан үүргийн дагуу гүйцэтгэсэн гэж үнэлэгдсэн болно.

5. Монголбанкны төв байранд ялтсан бойлер тавих ажил гүйцэтгэх. Үаб-2016/01

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-40 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийн шалгаруулалтад 3 байгууллага материал ирүүлсэн байна. 2016 оны 06 дугаар сарын 22-ны байдлаар судалж үзээд “Альянс тех” ХХК-ийн ирүүлсэн тендерийн материалыг “хамгийн сан үнэлэгдсэн” тендерээр шалгаруулж 2016 оны 06 сарын 22-ны өдөр 68,348,360.00 төгрөгөөр гэрээ байгуулах эрх зөвлөмжийг хүргүүлсэн байна. Үүний дагуу “Альянс тех” ХХК-тай 2016 оны 07 сарын 05-ны өдөр “Ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулсан. Шалгалт хамрах хугацаанд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар хийгдсэн бараа, ажил үйлчилгээг шалгаж үзэхэд худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах туха хууль”, “Монголбанкинд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журам”, “Монголбанкнаас байгуулах гэрээг хянах, бүртгэх, хадгалах журам”-ыг тус тус мөрдөж ажилласан байна гэж дүгнэсэн

Худалдах, худалдан авах гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, түрээсийн гэрээ, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, даатгалын гэрээ, зохиогчийн хяналт тавих гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ, үйлчилгээ үзүүлэх гэрээ нийт 160 гэрээ байгуулагдсан байна.